

ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН
“ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2009 оны жилийн эцсийн байдлаар

2010.02.15

Д.д	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл							
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо		Хөтөлбөрийг Засгийн газрын 2008.02.13-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан.							
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа		2008-2016 он							
3	Хөтөлбөрийн зорилго		Хөтөлбөрийн зорилго нь хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэхэд оршино.							
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: 1. Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх; 2. Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоод үйлдвэрлэлийг өргөжүүлэх; 3. Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх; 4. Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх; 5. Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах.							
		Нэгдүгээр үе шат 2008 - 2010 он	а/ үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн орчин болон стандартыг шинэчлэн бүрдүүлэх; б/ үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэж, техник, технологийн шинэчлэлийг эхлүүлэх; в/ дотоодын зах зээлд салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх;							
		Хоёрдугаар үе шат 2011-2016 он	а/ үйлдвэрлэл бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, дотоод зах зээлд эзлэх байр суурийг өсгөн бататгах; б/ орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; в/ салбарын үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.							
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	2008-2010 онуудад хэрэгжүүлэх арга хэмжээнд улсын төсвөөс 300 сая, олон улсын зээл тусламжаар 300 сая, хөнгөлөлттэй зээлээр 35170,0 сая төгрөг зарцуулахаар тусгасан. Нийт 35770 сая төгрөг.							
		Гүйцэтгэл	21465.0 мянган төгрөг							
		тухайн жилд зарцуулсан	21465.0 мянган төгрөг							
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлт	Нийт	90%	70%	50%	30%	10%	Тасарсан	Дундаж
		I шатны хэрэгжилтийн явц	5		1 /1/		1/5/	2 /3,4/	1 /2/	25%

7	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
8	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа	<p>“Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 81 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан ба уг төлөвлөгөөнд хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээний 26 ажил тусгажээ.</p> <p>Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - УИХ-ын 2009 онд баталсан “Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2012 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаагаар чөлөөлөх” тухай хууль, Засгийн газрын 2009.10.14-ний өдрийн хуралдаанаар баталсан татвараас чөлөөлөгдөх ЖДҮ-ийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслэлийн жагсаалтад хэвлэлийн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хамруулав. - Өндөр хөгжилтэй орнуудын хэвлэлийн үйлдвэрлэлийн стандартыг орчуулах, зарим шаардлагатай үндэсний стандартуудыг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ОХУ, Япон, Германы хэвлэлийн хуулийг орчуулсан. <p>Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хэвлэлийн үйлдвэрлэлийн импортын хараат байдлыг багасгах техник технологийн шийдлүүдийн судалгаа хийх ажлын хэсгүүд байгуулан мэргэжлийн ном, гарын авлага зохион ажиллаж байна. <p>Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - МХҮХ-той хамтран хэвлэлийн үйлдвэр байгуулах төсөл боловсруулж хэвлүүлэн, товхимолыг бизнес эрхлэгчдэд хүргэв. <p>Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Салбарын ажил мэргэжлийн ангиллыг шинэчлэн батлах, хөдөлмөрийн тариф мэргэжлийн үндсэн нормативыг шинэчлэн боловсруулж батлуулахаар НХХЯ-нд хүргүүлсэн. - Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдэж байна. 	<p>- Улаанбаатар хотод 200, орон нутагт 20 гаруй аж ахуйн нэгж хэвлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хэвлэл, цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2009 онд 13240.7 сая төгрөг болж, урьд оны мөн үеэс 11 хувиар буурч, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.7 хувийг эзэлж байна. - Үйлдвэрлэлийг бүтээгдэхүүний нэр төрлөөр авч үзвэл 2009 онд номын хэвлэлт 18.1 хувиар, дэвтэр үйлдвэрлэлт 2 дахин, бичгийн цаас 11,2 хувиар өсч, сонингийн цаас үйлдвэрлэлт 17 хувиар, сонин хэвлэлт 42 хувиар буурсан байна. - Салбарт ажиллагсдын тоо 2009 онд 1422 болж, 15.9 хувиар өсчээ.

9	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 81 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хэвлэлийн үйлдвэрлэл" хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг дүгнэн хийв.</p> <p>Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат 2008-2010 оны арга хэмжээний хэрэгжилтийн явц 2009 оны жилийн эцсийн байдлаар 25 хувийн биелэлттэйгээр дүгнэгдлээ. Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилтын арга хэмжээнүүд амжилттай хэрэгжин хэвлэлийн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2012 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаагаар чөлөөлөв. Харин үндэсний стандартуудыг боловсруулах арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.</p> <p>Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоод үйлдвэрлэлийг өргөжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 8 арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй, эдгээрээс 2 нь 2008-2009 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч биелээгүй байна.</p> <p>Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх зорилтын хүрээнд 6 арга хэмжээ төлөвлөжээ. Хэвлэлийн үйлдвэрлэлийн импортын хараат байдлыг багасгах техник технологийн шийдлүүдийн судалгаа хийх ажил эхэлсэн. 2008-2009 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтыг сайжруулах лаборатори байгуулах, техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох, тоон технологийг нутагшуулах зэрэг арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Орон нутгийн хэрэглэгчдэд ном, хэвлэлийг хүргэх, хэвлэлийн түүхий эдийг орон нутгийн үйлдвэрүүдэд түгээх сүлжээ бий болгох арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.</p> <p>Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах зорилтын хүрээнд тодорхой ажил хийгдэн, салбарын ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөрийн тариф, мэргэжлийн үндсэн нормативыг шинэчлэн боловсруулжээ. Нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх зохион байгуулалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна.</p>
10	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй шалтгаан	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүйгээс хамаарч хөтөлбөрийн арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байна.
11	Эдгээрээс гарах арга зам	<ul style="list-style-type: none"> - Салбарын хөгжлийн стратеги болон дотоодын зах зээлийн нөөц, хэрэгцээ шаардлагыг тооцон төв, орон нутагт салбарын үйлдвэр байгуулах чиглэлийг тодорхойлсон баримт бичиг боловсруулах, - Хэвлэлийн үйлдвэрлэлийн үндэсний стандартуудыг боловсруулах ажлыг эрчимжүүлэх, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулах асуудлыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх, - ЖДҮ дэмжих хөнгөлөлттэй зээлийн зохих хувийг орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ байгуулах, ном хэвлэл түгээх сүлжээ бий болгох төслийг дэмжих зориулалттай болгох, - Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг холбогдох яамтай хамтран зохион байгуулах, - Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг улам сайжруулах, хөтөлбөрийн үе шатны зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон тухайн оний үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүрэх үр дүн, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхой тусган боловсруулах, хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүжилтийн эх

		үүсвэрийг тухай бүр гаргуулах асуудлыг шийвэрлүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан жил бүр хэлэлцэн, хэрэгжилтийг ханган ажиллах, - Хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 2008-2009 онуудад хэрэгжүүлж эхлэх арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд анхаарч ажиллах.
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын мэргэжлийн холбоо, түүний гишүүд сайн ажилласан. Цаашид холбогдох төрийн байгууллагууд, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, их дээд сургуулийн хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.
13	Хөтөлбөрийн талаархи яамны санал	- Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, - Хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА